



НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА



Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид
Ноолуурын салбарын бэлэн бүтээгдэхүүний
борлуулалт
Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
нийлүүлэлт
Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зах зээлд
эзлэх хэмжээ
Ноолууран бүтээгдэхүүний экспорт
Сүлжмэл бэлэн хувцас болон малгайны импорт

51

Сүлжмэл ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлд
үйл ажиллагаа явуулж байгаа ААН

₮194тэрбум

Ноолуурын салбарын нийт бэлэн бүтээгдэхүүний
орлого

720,000

Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт, тоо хэмжээгээр

73,1тэрбум

Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт, мөнгөн дүнгээр

\$10,3сая

Сүлжмэл болон бэлэн хувцасны импорт



Хүснэгт 4. Аймгуудын үйлчилгээний газруудын тоон мэдээлэл, 2017 он

		Жуулчны бааз	Зочид буудал	Амралтын газар	Гэр буудал	Мотел дэн буудал	Рашаан сувилал
Төвийн бүс	Улаанбаатар	109	154	0	0	136	0
	Сэлэнгэ	10	40	16	0	0	2
	Зуунмод	36	5	15	0	0	33
	Дархан	0	27	8	0	16	2
	Дорноговь	6	26	60	14	0	3
	Дундговь	10	5	0	3	9	1
	Өмнөговь	25	59	3	31	0	3
Хангайн бүс	Архангай	26	29	0	0	0	0
	Өвөрхангай	30	11	6	31	7	4
	Баянхонгор	6	11	8	3	34	6
	Булган	17	3	83	0	10	2
	Эрдэнэт	0	26	5	0	16	0
	Хөвсгөл	74	16	0	130	14	17
Баруун бүс	Баян-Өлгий	8	5	0	0	0	0
	Увс	8	7	3	4	2	3
	Ховд	3	8	2	2	10	2
	Говь-алтай	3	7	2	2	40	3
	Завхан	10	10	0	0	5	5
Зүүн бүс	Дорнод	0	8	11	1	19	0
	Хэнтий	15	34	7	0	0	2
	Сүхбаатар	6	26	60	14	0	3
НИЙТ		495	507	284	232	284	86

Эх сурвалж: Жуулчны мэдээллийн төв

Аялал жуулчлалын мэргэшсэн байгууллага болон үйлчилгээний газрын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь манай улсад аялал жуулчлалын салбар хөгжих нөхцөл бүрдэж байгааг харуулах нэг үзүүлэлт мөн боловч аялалын дэд бүтэц хөгжөөгүй, үйлчилгээний байгууллагуудын чадавх сул, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, жуулчны баазуудын үйлчилгээний стандарт дээшилж тогтворжоогүй, аялал жуулчлалын бүс нутгуудад хэт ачаалал үүссэн зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд сөрөг нөлөөтэй гэсэн нийтлэг дүгнэлтүүд гарсан байна.



НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА



Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид
Ноолуурын салбарын бэлэн бүтээгдэхүүний
борлуулалт
Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
нийлүүлэлт
Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зах зээлд
эзлэх хэмжээ
Ноолууран бүтээгдэхүүний экспорт
Сүлжмэл бэлэн хувцас болон малгайны импорт

51

Сүлжмэл ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлд
үйл ажиллагаа явуулж байгаа ААН

₮194тэрбум

Ноолуурын салбарын нийт бэлэн бүтээгдэхүүний
орлого

720,000

Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт, тоо хэмжээгээр

73,1тэрбум

Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний дотоодын
үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт, мөнгөн дүнгээр

\$10,3сая


Сүлжмэл болон бэлэн хувцасны импорт



НООЛУУРАН СҮЛЖМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧИД

Ноолуурын зах зээлд 2016 оны байдлаар нийт 239 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас гадаад улсаас /Солонгос, Тайвань, Хятад/ болон дотоодын ээрэх үйлдвэрүүдээс бэлэн ээрмэл утас худалдан авч сүлжмэл эдлэл үйлдвэрлэдэг, сүлжмэлээр дагнадаг нийт 51 аж ахуйн нэгж байна. Ажиллах хүчний хувьд сүлжих үйлдвэрт нийт ноолууран үйлдвэрлэлийн салбарын ажилчдын 10 хувь буюу 560 ажилтан хамаарч байна.

Зураг 1. Ноолуурын үйлдвэрүүдийн үйл ажиллагааны чиглэл ба ажиллах хүчний хувиарлалт



Эх сурвалж: МИРИМ Консалтант ХХК-ийн дотоод мэдээллийн сан

Ноолууран сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дотоодын 51 аж ахуйн нэгж байна.

НООЛУУРЫН САЛБАРЫН БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Монголын ноолуурын салбарын нийт бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого 2016 оны байдлаар 194 тэрбум төгрөг, 2015 оны байдлаар 150 тэрбум төгрөг байна. Борлуулалтын орлогоор том 5 аж ахуйн нэгжийн тоонд Говь ХК, Сор Кашмер ХХК, Кашмер Холдинг ХХК, Натурал Текстайл Групп ХХК, Гоёо ХХК орж байна. Эдгээр компаниуд нь нийт борлуулалтын орлогын 81.4 хувийг эзэлж байна. Говь ХК-ийн борлуулалтын орлого нийт борлуулалтын орлогын 46.5 хувийг дангаараа эзэлж байна.

Манай улсын хувьд нийт бэлэн бүтээгдэхүүний 60 орчим хувь нь дотоод зах зээлд борлогдож байна. Манай улсад ирж буй жуулчид энэхүү зах зээлийг бүрдүүлэх чухал хүчин зүйл болж байна. Жуулчдын худалдан авалтын хэмжээ нь нийт дотоодын зах зээл дэх борлуулалтын 30 орчим хувийг эзэлдэг¹.

Нийт худалдан авалтанд эзэлж буй экспорт болон гадаад жуулчдын худалдан авалтын хэмжээ 58 хувь байна. Түүнчлэн, дотоодын худалдан авагчдын худалдан авалтанд гадаад танил, найз нөхөд, түншдээ бэлэг дурсгалын зориулалтаар худалдан авч байгаа хүмүүс цөөнгүй байна.

₮194тэрбум	Нийт бэлэн бүтээгдэхүүний орлого
₮78тэрбум	Экспортын орлого
₮116тэрбум	Дотоодын зах зээлийн орлого
₮81тэрбум	Дотоодын худалдан авагчдын худалдан авалт
₮35тэрбум	Гадаадын жуулчдын худалдан авалт

¹ Говь ХК, Жилийн тайлан 2016 он

НООЛУУРАН СҮЛЖМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДОТООДЫН НИЙЛҮҮЛЭЛТ

Монгол улсын нийт сүлжих үйлдвэрийн хүчин чадал 3,400,000 ширхэг бүтээгдэхүүн байгаагаас 2016 оны байдлаар жилд 1,200,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Дотоодын зах зээлд бэлэн бүтээгдэхүүний 60 хувийг борлуулдаг тул сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний дотоод зах зээл дахь нийлүүлэлт 720,000 ширхэг болж байна.

Ноолууран сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг нийт 51 аж ахуйн нэгж байгаагаас топ 5 нийлүүлэгчид 2016 оны байдлаар Говь ХК, Сор Кашмер ХХК, Кашмер Холдинг ХХК, Натурал Текстайл Групп ХХК, Гоёо ХХК, Үлэмж Кашмер ХХК орж байна.


Сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн тоо ширхэгийн хувьд Говь ХК-ийн мэдээлэлд үндэслэн салбарын нийлүүлэлтийг тооцоолов. Говь ХК жилд 1,000,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ба 2016 онд 521,853 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, сүлжмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлого 53 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс дотоод зах зээл дахь нийлүүлэлтийг дээр дурьдсан 60 хувь гэсэн мэдээллийг ашиглан тооцоход дараах үр дүн гарч байна.

720,000	Нийт салбарын дотоод зах зээлд борлуулж буй сүлжмэл бүтээгдэхүүний нийлүүлж буй хэмжээ
73.1тэрбум	Нийт салбарын дотоод зах зээлд борлуулж буй сүлжмэл бүтээгдэхүүний мөнгөн дүн

НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь хэмжээг борлуулалтын орлого гэсэн үзүүлэлтээр тодорхойллоо. Ноолууран бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 51 аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 2016 оны байдлаар 194 тэрбум төгрөг байна. 2016 оны борлуулалтын орлогоор зах зээлд эзлэх хувь хэмжээг тодорхойлоход Говь ХК хамгийн өндөр нь буюу зах зээлийн 46 хувийг эзэлж байна. Үүний дараагаар Сор Кашмер ХХК 10 хувь, Кашмер Холдинг ХХК 9 хувь, Натурал Текстайл Групп 8 хувь, Гоёо ХХК 8 хувь, Үлэмж Кашмер ХХК 3 хувь, Мониталкашмер ХХК 3 хувь, бусад компаниуд 13 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2. Зах зээлд эзлэх хувь, борлуулалтын орлогоор, 2016 он




Эх сурвалж: МИРИМ Консалтант ХХК-ийн дотоод мэдээллийн сан

НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Монгол улсын боловсруулах аж үйлдвэрийн нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүний 36 хувийг ноос, ноолууран бүтээгдэхүүн эзэлж байгаа нь том үзүүлэлт юм.

Зураг 3. Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл, экспортын сагсны бүтцээр, 2016 он



Эх сурвалж: Говь ХК-ийн жилийн тайлан 2016 он

Монголын ноос, ноолуурын холбооноос гаргадаг статистик мэдээллээр 2016 онд самнасан ноолуурын экспортын хэмжээ буурч бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн таатай үзүүлэлт харагдаж байна. Харин түүхий ноолуур буюу угаасан ноолуурын борлуулалт жил ирэх тутам өссөн хэвээр байна.

Зураг 4. Ноолуурын экспортын хэмжээ ба мөнгөн дүн 2015-2016, ноолуурын төрлөөр /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Монголын ноос, ноолуурын холбоо

2016 онд нийт 626,5 тэрбум төгрөгийн ноолуурыг экспорт хийснээс нийт орлогод угаасан ноолуур 73.7%, самнасан ноолуур 13.0%, бэлэн бүтээгдэхүүн 13.3%-ийг тус тус эзэлжээ.

2015 онтой харьцуулбал самнасан ноолуурын экспортын нийт үнийн дүн буурч бэлэн бүтээгдэхүүний экспортын дүн нэмэгджээ.

Зураг 5. Ноолуурын экспортын хэмжээ 2015-2016, ноолуурын төрлөөр



Эх сурвалж: Монголын ноос, ноолуурын холбоо

өмнөх оныхоос 25%-аар өсчээ. Өдөрт дунджаар 210 ширхэг пальто, 50 минутанд 6000 ширхэг эмэгтэй цамц борлуулагдаж байгаа гэсэн сонирхолтой статистикийг Говь ХК танилцуулгадаа дурьджээ.

Хэрэв зөвхөн Говь ХК-ийн бүтээгдэхүүний борлуулалтын мэдээг харвал пальтоны борлуулалт 2017 оны 11 сарын байдлаар өмнөх оныхоос 5.2 дахин өсөлттэй, сүлжмэл хувцасны борлуулалт

Хүснэгт. Говь ХК бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын мэдээ


	2015	2016	2017
Сүлжмэл хувцас	415.000	480.000	600.000
Пальто	11.000	19.000	100.000

Эх сурвалж: Говь ХК-ын 2016 оны тайлан

СҮЛЖМЭЛ БЭЛЭН ХУВЦАС БОЛОН МАЛГАЙНЫ ИМПОРТ

Сүлжмэл бэлэн хувцасны импорт: Нийт сүлжмэл хувцасны импортын бүтэц болон түүнд эзлэх хувь, үнийн дүнг Зураг 15-д үзүүлэв. Монгол улс 2016 онд нийт 10.3 сая ам.долларын сүлжмэл хувцас болон хувцасны тоног хэрэгсэл импортлосон байна. Үүнээс хувцасны тоног хэрэгсэл 146,800 ам.доллар буюу 1.4 хувь байна. Зураг 4-д үзүүлснээр нийт сүлжмэл бэлэн хувцасны импортын хамгийн их буюу 26 хувийг свитер болон бусад сүлжмэл гадуур цамц (2.7 сая ам.доллар), 22 хувийг футболка, майк (2.3 сая ам.доллар), 15 хувийг эмэгтэй костюм, платье, банзал, өмд (1.6 сая ам.доллар) эзэлж байна.

Зураг 6: Сүлжмэл хувцасны импорт, нэр төрлөөр, хувиар




Эх сурвалж: Гаалийн мэдээ 2016 он

Сүлжмэл эрэгтэй, эмэгтэй пальто, цув, хүрэмний хувьд импорт харьцангуй бага хувийг эзэлж байна. Хүүхдийн сүлжмэл хувцасны импортолж буй тоо ширхэг олон (77,507 ширхэг) боловч үнэ хямд байдаг тул нийт импортын дөнгөж 3 хувийг эзэлж байна.

Сүлжмэл болон нэхмэл малгайны импортын нийлүүлэлт: Сүлжмэл, нэхмэл малгайны импорт 2016 онд 440 мянган ам.доллар байсан бөгөөд үүний 53 хувь буюу 234 мянган ам.долларын импортыг БНХАУ-аас, 9 хувь буюу 38 мянган ам.долларын импортыг Австрали улсаас тус тус хийжээ


Зураг 7. Малгайны импорт, мянган ам.доллар



Ноосон бэлэн хувцасны импорт:

Ноосон бэлэн хувцасны импортыг бүтээгдэхүүн тус бүрээр 2014 оноос 2016 оны хооронд харуулав. Ихэнхи бүтээгдэхүүний хувьд импортын үнийн дүн 2014 онд бусад онтой харьцуулахад өндөр, 2015 онд огцом багассан бөгөөд 2016 оноос буцаад өсөх төлөв ажиглагдаж байна.

Зураг 8. Ноосон бэлэн хувцасны импорт, он тус бүрээр (мян.ам доллар)



Эх сурвалж: www.trademap.org

Импортын үнийн дүнгийн хэмжээгээр 2016 оны байдлаар ноосон свитер, гадуур цамц 65 хувийг, костюм, платье, банзал, өмд (эм) 21 хувийг, бээлий 8 хувийг, костюм, жакет, өмд (эр) 6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 9. Ноосон бэлэн хувцасны импортын бүтэц, 2016 он



Эх сурвалж: www.trademap.org

Ноолууран свитер, гадуур цамцны импорт:

Ноолууран свитер, гадуур цамцны импортын хувьд 2014 онд 34 мянган ам.доллар буюу 85 сая төгрөгийн бүтээгдэхүүн импортолж байсан бол 2016 онд нийт 75 мянган ам.доллар буюу 187.5 сая төгрөг хүртэл өсчээ.

Улс тус бүрээр авч үзэхэд 2016 оны байдлаар Япон улсын ноолууран свитер, гадуур цамцны импорт хамгийн их буюу 41 мянган ам.доллар байна. 2014 онд Япон улсаас импортолж байгаагүй боловч 2015 онд 8 мянган доллар, 2016 онд 5.1 дахин буюу 41 мянган ам.доллар болтлоо өсчээ. Япон улсын дараагаар Итали улсаас 15 мянган ам.доллар, Хятад улсаас 13 мянган ам.доллар, бусад улсуудаас 6 мянган ам.долларын свитер, гадуур цамц импортолсон байна.

Сүлжмэл бэлэн хувцасны импорт 2016 оны байдлаар 10.3 сая ам.доллар (25.8 тэрбум төгрөг), сүлжмэл болон нэхмэл малгайны импорт 440 мянган ам.доллар (1.1 тэрбум төгрөг), ноосон бэлэн хувцасны импорт 248 мянган ам.доллар (620 сая төгрөг), ноолууран свитер, гадуур цамцны импорт 75 мянган ам.доллар (187.5 сая төгрөг) байна.

Дүгнэлт:

Сүлжмэл ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлд үйл ажиллагаа явуулж буй нийт 51 аж ахуйн нэгж байна.

Ноолуурын салбарын нийт бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого 2016 оны байдлаар 194 тэрбум төгрөг, Говь ХК, Сор Кашмер ХХК, Кашмер Холдинг ХХК, Натурал Текстайл Групп ХХК, Гоёо ХХК нийт орлогын 81.4 хувийг, Говь ХК дангаараа 46.5 хувийг эзэлж байна.

Ноолууран сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэгчдийн дотоод зах зээл дахь нийлүүлэлт 720,000 ширхэг, 73.1 тэрбум төгрөг байна.

Сүлжмэл бэлэн хувцасны импорт 2016 оны байдлаар 10.3 сая ам.доллар (25.8 тэрбум төгрөг), сүлжмэл болон нэхмэл малгайны импорт 440 мянган ам.доллар (1.1 тэрбум төгрөг), ноосон бэлэн хувцасны импорт 248 мянган ам.доллар (620 сая төгрөг), ноолууран свитер, гадуур цамцны импорт 75 мянган ам.доллар (187.5 сая төгрөг) байна. Ноолууран свитер, гадуур цамцны импортын хувьд Япон улс 55 хувийг эзэлж байна.